

**МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН  
ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ  
ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ/Архангай/**

**4.1 Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого**

**Стратегийн зорилт 1.Ядууст чиглэсэн, харьцангуй чинээлэг дунд давхаргыг төлөвшүүлэх эдийн засгийн бодлого хэрэгжүүлж, орлогын өсөлтийг хангах замаар ядуурлыг 2 дахин бууруулна:**

“Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах аймгийн дэд хөтөлбөр” боловсруулан аймгийн Засаг даргын 2009 оны тоот 97 тоот захирамжаар батлуулан сум бүрт жил бүр ядуурлаас гаргах өрхийн тоог хуваарилсны дагуу 2009 онд 475 ядуу өрхийг сонгон авч эдгээр өрхийн гишүүдээс 227 иргэнийг нийтийг хамарсан ажилд оролцуулж 17.850 мян төг, 96 иргэнийг мэргэжлийг чиг баримжаа олгох сургалтанд хамруулж 10.5 сая.төгрөг, 26 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулж 962.0 мян төг, 36 иргэнийг хөдөлмөр эрхлэх жижиг зээлд хамруулж 115.2 сая төг, 8 хүнийг байнгын ажлын байранд хамруулж ажил олгогчид 4640.0 мян төгрөгний урамшуулал олгосны үр дүнд эдгээр өрхийн 65 хувийн орлого сар бүр 50.0-80.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

“Тогтвортой амьжиргаа 2” төслийн хүрээнд 2009 онд сумдаас нийт 230 төслийг хүлээн авч “Олон нийтийн санаачилгын сан”-гаас 102 төслийг 484.0 сая төгрөгийн санхүүжилттэй хэрэгжүүлж байгаагаас Боловсролын чиглэлийн 35 төсөлд 133.3 сая төгрөгийн, Эрүүл мэндийн салбарын 21 төсөлд 87.9 сая төгрөгийн, дэд бүтцийн чиглэлийн 32 төсөлд 197.9 сая төгрөгийн бусад чиглэлийн төслүүдэд 64.9 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус зарцуулсан байна.

“Бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийн удирдлагын сан”-гаас нийтдээ 120 төслийг 233.6 сая төгрөгөөр санхүүжигдэн хэрэгжиж байна. Дээрх хоёр чиглэлийн төслүүдийн үр дүнд нийтдээ давхардсан тоогоор 60 орчим мянган өрхийн 200 гаруй мянган хүн ашиг хүртэж байгаагийн 100 гаруй мянган эмэгтэйчүүд байна. Эдгээр ажлыг гүйцэтгэсэнээр 70 гаруй хүн түр ажлын байраар хангагдсан байна.

ХЯБХ-ийн Нийгмийн хөгжлийн дэд хэсгийн хүрээнд Цэцэрлэг, Төвшрүүлэх, Булган, Ихтамир сумдад ХАС банкаар дамжуулан нийгмийн эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн 16 бүлэгт 27313.0 мян төгрөгний зээл олгосон байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 70 төслийг 845.0 сая төгрөгөөр санхүүжүүлж 186 ажлын байр шинээр бий болсон байна. Эдгээр төслөөс хүнсний үйлдвэрлэлээр -18, ХАА-н чиглэлээр -19, хөнгөн үйлдэрлэлээр -12, барилгын материалын үйлдвэрлэлээр -9, ахуйн үйлчилгээний чиглэлээр -11, худалдаа үйлчилгээний чиглэлээр -1 төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Аймгийн хэмжээнд төсөл хөтөлбөр болон улс, орон нутгийн төсвийн санхүүжилт, ААН, байгууллагын хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлын хүрээнд нийт 1628 ажлын байр шинээр бий болсны 442 нь тогтмол ажлын байр байна. Ажилгүйдлийн түвшин 4,34 хувь, хүн амын ядуурлын түвшин 32.2 хувь болж өмнөх оныхоос 0.03 хувиар өссөн нь эдийн засгийн хямрал, цаг зудын байдалтай холбогдолтой гэж үзэж байна.

**4.2 Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого**

Жендэрийн тэгш байдлыг гэр бүл, эдийн засаг, нийгэм улс төр, соёл, хүний эрхийн хүрээнд хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

**Стратегийн зорилт 1.** Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг үндэсний соёлын дэвшилтэт уламжлал, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололттой хослуулан төлөвшүүлнэ. Архангай аймгийн нийт хүн ам 89331 үүний 50.5 хувийг эмэгтэйчүүд, нийгмийн салбарт ажиллагсдын 70 гаруй хувийг эмэгтэйчүүд, аймгийн иргэдийн хурлын 31 төлөөлөгчөөс 7 эмэгтэй, 19 сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нарын 8 эмэгтэй, 19 ИТХ-ын нарийн бичгийн дарга нарын 8 нь эмэгтэй, аймгийн төрийн байгууллагын удирдах албан тушаалтны 40 гаруй хувь нь эмэгтэйчүүд байна.

Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн төсвийн ерөнхийлөн захирагчтай аймгийн Засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн талаар 2009 онд байгуулсан гэрээний дагуу Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Эрэгтэй эмэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг хариуцлага, тэгш байдлын талаарх олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалт сурталчилгааг зохион байгуулах” сургалтын төслийг хэрэгжүүллээ. Тухайн төслийн хүрээнд Эрдэнэбулган, Хайрхан, Батцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн 250 сурагч, 20 багшид тус бүр 2 өдрийн сургалт зохион байгуулж гарын авлага материалаар хангасан байна. Сургалтын хөтөлбөрт Төрөөс хүн ам ба хөгжил, жендэрийн асуудлаар баримталж байгаа бодлого, Хүний эрх аюулгүй байдал, жендэрийн асуудлууд, Боловсролын салбарт жендэрийн тэгш байдлын хангах нь, Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн тухай, Гэр бүлийн харилцаан дахь жендэрийн тэгш байдал, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаар, Гэр бүл төлөвлөлт, Мэргэжлээ зөв сонгох тухай зэрэг сэдвээр сургалт хийж дадлага дасгал хийлгэсэн нь сурагчид залуучуудын сонирхлыг татаж талархлыг хүлээсэн мэдээлэл болсон байна.

#### **4.3 Гэр бүлийн хөгжил, хүн ам зүйн бодлого**

**Стратегийн зорилт 1.** Гэр бүлийг хүний аж төрөх таатай орчин болгоход чиглэсэн цогц бодлого хэрэгжүүлнэ.

Аймаг, сумдын Засаг даргын тамгын газартай хамтран өсвөр үе залуучуудад Ардын уламжлалт ёс заншил, үндэсний өв уламжлалын талаар сургалт зохион байгуулж нийт 19 сумын 2600 гаруй хүүхдийг хамруулсан байна.

Аймгийн хэмжээнд нийт өнчин хүүхэд 2162 үүнээс 0-6 насны хүүхэд 226, 7-15 насны хүүхэд 1318, 16-18 насны хүүхэд 618 байна. Эхтэйгээ хамт тэнүүчлэн амьдардаг 9 настай хүүхдэд Дэлхийн зөн олон улсын байгууллагаас байшин барьж орон гэртэй болгосон байна. Нийгмийн халамжийн сангаас бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж байгаа 72 иргэнд 17044.6 мян төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж олгосон байна.

Өрх бүр Угийн бичгээ хөтлөх талаар сумдын ЗДТГ, төрийн бус байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж байна. Жаргалант, Цэцэрлэг, Төвшрүүлэх зэрэг сумдын 6 өрх Ургийн баяраа хийсэн нь өөрсдийн удам угсаагаа мэдэлцэж бусад иргэдэд үлгэр дууриал болсон байна.

Монгол улсын хүн амын насжилтийн асуудлаарх үндэсний стратегийн талаар аймаг, сумдын ЗДТГ-ын ажилтнууд, сумдын нийгмийн ажилтнуудад сургалт зохион байгуулж аймгийн дэд хөтөлбөр боловсруулахаар холбогдох байгууллагаас судалгаа, санал ажлын чиглэлийг авч байна.

**Стратегийн зорилт 2.** Хүн амын эмзэг бүлгийн хөгжлийг дэмжих хүний эрхэд суурилсан гэр бүл төвтэй төрийн цогц бодлого хэрэгжүүлнэ.

Флом байгууллагын санхүүгийн дэмжлэгээр “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв”-ийг байгуулсан. Энэ төвийн үйл ажиллагааг тогтвортой байлгах цаашид төвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор Аймгийн Засаг дарга, Флом байгууллага, ХХҮХ-ийн хооронд хамтран ажиллах 3 талт гэрээ байгуулсны дагуу 2010 оноос энэ төвийн урсгал зардлын тодорхой хэсгийг орон нутаг болон улсын төсвөөс санхүүжүүлж байхаар төлөвлөөд байна.

Энэ төв дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд хөдөлмөр эрхлэх, мэдээллээр хангагдах, уламжлалт бариа заслын үйлчилгээнд хамрагдах зэрэг олон төрлийн үйлчилгээнд хамрагдах боломж нээгдэж байна.

Аймгийн Засаг даргын 2009 оны 139 тоот захирамжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон иргэд чөлөөтэй зорчих дэд бүтцийг бий болгох, ерөнхий боловсролын сургуулийн анги танхимын ширээ сандлыг хэрэгцээнд нь тулгуурлан хийх талаар үүрэг чиглэл өгсний дагуу Эрдэнэбулган суманд үйл ажиллагаа явуулж байгаа төр, хувийн хэвшлийн 9 байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөтэй зорчих налуу замыг стандартын дагуу хийж иргэдэд үйлчилгээг шуурхай хүргэж байна.

Мөн Ирээдүй Цогцолбор, Билгүү сургууль дээр тус бүр хөгжлийн бэрхшээлтэй 15 хүүхэдтэй тусгай ангийг хичээллүүлж хүүхдийн онцлог хэрэгцээнд тохирсон ширээ сандал хичээлийн хэрэглэгдэхүүнийг ашиглан сургалт хүмүүжлийн ажлыг явуулж байна.

Аймаг сумдын 29 цэцэрлэгт нийт 43 хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцаж байна.

**Стратегийн зорилт 3.** Эцэг эх, үр хүүхдээ эрүүл, саруул өсгөн бойжуулж, боловсрол хүмүүжлийн зөв төлөвшилтэй болгон хөгжүүлэхэд чиглэсэн гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхийг төрөөс дэмжинэ. Төрөлтийг дэмжих замаар хүн амын жилийн дундаж өсөлтийг нэмэгдүүлж, улмаар хүн амаа өсгөх бодлого баримтална.

Жирэмсэн эхчүүдийн эрүүл мэндийн даатгалын хураамжийг хүүхдийг 2 нас хүртэл нь, эх ажиллаж байсан бол байгууллагаас нийгмийн даатгалын шимтгэлийг нь төлж байна. Нийгмийн халамжийн сангаас 3502 эхэд 604460.3 мян төгрөг, нийгмийн даатгалын сангаас 245 эхэд 73,5 сая төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж олгосон байна.

#### **4.4. Боловсролын хөгжлийн бодлого**

Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ. “Боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. 2008 оноос ерөнхий боловсролын 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэн 2015 он гэхэд хөвгүүд, охидыг бага боловсролд бүрэн хамруулж, хүйсийн тэгш бус байдлыг арилгана. Ур чадвар сайтай мэргэжилтэй ажилтан бэлтгэх, дээд боловсрол олгох тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх бодлого баримтална. 2021 он гэхэд олон улсын жишигт нийцсэн боловсролын тогтолцоонд шилжинэ. Орон даяар оюун ухааныг эрхэмлэн дээдэлж амьдрах сэтгэл зүйн орчин бүрдүүлж, боловсролын бүх шатны сургалтыг 21 дүгээр зууны оюунжсан шинэ хандлагад зохицуулан өөрчилнө.

**Стратегийн зорилт 1: Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ.**

2009 оноос цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг төрөөс 100% хариуцан 1 хүүхдийн хоолны зардлыг 1100 төгрөг болгосон. 2009-2010 оны хичээлийн жилд аймгийн

хэмжээнд хүүхдийн цэцэрлэгт 2931 хүүхэд хамрагдаж цэцэрлэгийн насны хүүхдийн 45.8 хувь, СӨБ-ын бусад хэлбэрийн буюу хувилбарт сургалтанд 1756 буюу 29.2 % хувь нь хамрагдаж СӨБ-ийн хамран сургалт 75.0%-тай байна.

Боловсрол, нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх чиглэлээр аймгийн 19 суманд ЕБС-ийг түшиглэн 19 "Гэгээрэл төв" үйл ажиллагаагаа явуулж байна.

2009-2010 оны хичээлийн жилд боловсрол нөхөн олгох дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд 9-өөс дээш насны 611 суралцагч хамрагдаж байгаа бөгөөд бага боловсролд 338, суурь боловсролд 214, бүрэн дунд боловсролд 82 суралцагч тус тус хамрагдаж бичиг үсэгт тайлагдалт 98.8%-тай байна.

ЕБС-ийн суралцагчдын хүйсийн харьцаа эр/эм=**49.6%/50.4%**

ЕБС-ийн багш нарын хүйсийн харьцаа эр/эм= **19.9%/80.1%**

Хөдөөгийн малчин өрхийн 0-6 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг нүүдлийн аж байдалд нь тохируулан зохион байгуулж 2009 онд СӨБ-ийн хувилбарт сургалтаар ээлжийн бүлэгт 218, нүүдлийн цэцэрлэгт 1180, явуулын багшийн сургалтанд 368 нийт 1776 хүүхэд хамрагдаж байна.6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах зорилгоор судалгааг нарийвчлан гаргаж, эцэг эх, иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулж, сургуульд /1822 хүүхэд/ бүрэн хамруулаад байна. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тохилог орчинг бүрдүүлж, дотуур байранд 2884 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд дотуур байранд суухаар хүсэлт гаргасан хүүдийн 93.2%-ийг хамруулаад байна.

ЕБС-ийн бага ангийн сурагчдад хэрэгжүүлж буй "Үдийн цай" хөтөлбөрийг өргөжүүлэн "Үдийн хоол" болгон 7 хоногийн 2-5 өдөрт халуун хоол өгдөг болоод байна. ЕБС-иудын "Үдийн хоол" хөтөлбөрийн хэрэгжилт, чанар эрүүл ахуйн байдалд БСГ, Мэргэжлийн хяналтын газрын байцаагч нартай хамтран хяналт, үнэлгээ хийж орчин н

**Стратегийн зорилт 2: Боловсролын бүх түвшний стандарт, сургалтын хөтөлбөрийг тухайн үеийн суралцагчийн хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.**

Бага дунд боловсролын стандартад дунд шатны үнэлгээг улсын хэмжээнд зохион байгуулж байна.Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэх хүрээнд стандартад нийцүүлэн тухайн аймаг, сум, сургууль, багш нар өөрсдөө агуулгандаа орон нутгийн онцлогыг тусган баяжуулж сургалтын хөтөлбөрөө боловсруулан хэрэгжүүлж байна Англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгох хүрээнд англи хэлний үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Багш, боловсон хүчний чадавхийг сайжруулах зорилгоор англи хэлний 31 багш вакуумжуулсан 21 хоногийн сургалтанд хамруулж ЕБС-ийн 50 багшид "Lesson planner", "Dictionery for Kids", " Flashcards" гэсэн номноос бүрдсэн стандартын шаардлагад нийцсэн англи хэлний багц номоор хангах ажлыг зохион байгуулж, ашиглалтанд хяналт тавьж ажиллаж байна. Англи хэлний 40 багшийг онлайн сургалтанд хамруулав.

**Стратегийн зорилт 3: Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин хөлс, урамшуулал, нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, энэ чиглэлд хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлнэ.**

Багш, удирдах ажилтан бэлтгэх мэргэжил дээшлүүлэх тогтолцоог шинэчлэх үүднээс мэргэжил дээшлүүлэх журмыг шинэчлэн гаргаж 5, 10 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын судалгааг 3 жилээр гаргаж холбогдох газарт хүргүүлсэн болно.Мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан БСШУЯ-наас зөвшөөрөл авсан төрийн болон төрийн бус байгууллагын сургалтанд багш нар хамрагдаж мэргэжил б

Багш, боловсролын байгууллагын ажиллагсдын ажлын чанар, үр бүтээлийг үнэлэх үүднээс Монгол Улсын Засгийн газраас “Мөнгөн урамшуулал олгох тухай” 54-р тогтоолыг гаргаж улирал тутамд 45% хүртэлх хэмжээний мөнгөн урамшууллыг олгож байна. Сургууль, цэцэрлэгийн багш, удирдах ажилтан нарт орон нутгийн нэмэгдэл болох Монгол улсын Засгийн газраас гаргасан 90 тогтоолын дагуу орон нутгийн нэмэгдлийг олгож байна.

#### **4.5 Эрүүл мэндийн хөгжлийн бодлого**

**Стратегийн зорилт 1. Сум, өрхийн эмнэлгийн анхан шатны тусламж хүргэх, шинжилгээ, оношлогоо, эмчилгээ, дархлаажуулалт хийх, шүдний өвчин эмчлэх, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ, ДХО, сүрьеэгээс сэргийлэх, эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах чадамжийг цогц байдлаар хөгжүүлнэ.**

ХДХВ, ДХО, сүрьеэгээс сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор сургалт сурталчилгаанд нийт 1800 хүнийг хамруулан санамж, гарын авлагаар хангасан байна. Тайлангийн хугацаанд 116 хүнд 46 594 төгрөгний үнэгүй эмийг олгосон.

Сайн дурын зөвлөгөө шинжилгээний нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх “Халуун сэтгэл” кабинетаар 316 хүнд зөвлөгөө өгч, 287 хүнд сайн дурын шинжилгээ хийж, 1026 бэлгэвч тараасан байна. Үүнээс бэлгийн замын халдварт өвчтэй 5 илэрч урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг орон нутгийн сонин хэвлэл ТВ-ээр улирал тутам хийж ирлээ. Аж ахуй нэгж, байгууллага, бар ресторан үйлчилгээний газрын ажилтан, оюутнууд зэрэг 2000 гаруй хүнд 32 удаа аман ухуулга сурталчилгаа явуулан ДОХ ба бэлгийн замын халдварт өвчний тулгамдсан асуудал сэдэвт 2 хоногийн хичээлийг эмч нарт заалаа. Аймгийн төвд сумдын эмнэлгийн эрхлэгч, Засаг дарга, сумын тамгын газрын дарга, иргэний бүртгэлийн ажилчид, нийгмийн ажилчид, цагдаагийн байгууллага зэрэг 165-иад удирдах ажилтан, өсвөр үеийн 30 гаруй хүүхэд, иргэд 130, оюутан сурагчид 400 гаруй хүмүүст “ХДХВ/ДОХ/БЗДХ-аас сэргийлэх нь” сэдэвт 6 цагийн сургалтыг тус тус хийсэн байна.

**Стратегийн зорилт 2. Аймаг, дүүргийн болон улсын клиникийн нэгдсэн эмнэлэг, мэргэжлийн төвүүдийн үйл ажиллагааны чадамжийг хөгжүүлнэ.**

Эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэх, хэвтэн эмчлүүлэгчдийн үйлчилгээний ээлтэй байдлыг хангах зорилгоор аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийт 21 нэр төрлийн 23.9 сая төгрөгийн багаж төхөөрөмж, Цэцэрлэг, Батцэнгэл, Өлзийт, Цахир сумдын эмнэлгүүдийг зайлшгүй шаардлагатай 9 нэр төрлийн 15 багажаар хангасан байна.

**Стратегийн зорилт 3. Эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай боловсон хүчнээр хангана.**

Эрүүл мэндийн салбарт ажиллагсдыг чадавхжуулах, хангалтыг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлэн энэ онд 20 гаруй хүнийг урт хугацааны сургалтанд, давхардсан тоогоор 140 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтэнг богино хугацааны сургалтанд хамруулсан нь эмнэлгийн мэргэжилтнүүдийн 23.8 хувь нь 1 сараас дээш хугацааны сургалтанд хамрагдаж, их эмчийн хангалтын хувь 10 000 хүн амд 17.2, дунд мэргэжилтний хангалт 10 000 хүн амд 54.7 хувьд хүрсэн байна. Шинээр 6 их эмч, 8 дунд мэргэжилтэнг орон тоогоор авч ажиллуулсан байна.

**Стратегийн зорилт 4. Хүн амын өвчлөл, цаг бусын нас баралтыг бууруулж дундаж наслалтыг ахиулна. Эрүүл аж төрөх хэв маяг, эрүүл мэндээ хамгаалах зөв зан үйлийг төлөвшүүлнэ.**

“Идэвхтэй хөдөлгөөн Зохистой хооллолт” хөтөлбөр хэрэгжүүлэн бүх байгууллагуудын ажиллагсдыг чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох үзлэгт хамрууллаа.

Сүүлийн 9 жилд 200491 хүний бие бялдрын хөгжил чирэгжүүлэлтийн түвшинг тогтоож 151568 хүн эрүүлжүүлж чийрэгжүүлсэн байна.

2007 онд 10,2 хувь нь бие бялдрын хөгжил сул, жин өндрийн харьцаа алдагдсан байсан бол 2009 онд 9,5 хувь болж багассан байна. Аймгийн төв хавтгай модонд иргэд чөлөөт цагаа өнгөрүүлэх цэвэр агаарт бие бялдраа чийрэгжүүлэх Цанын баазыг байгуулав. Тамирын голд мөсөн шагай харвах талбайг сонгон аймаг сумдын тамирчдыг оролцуулан мөсөн шагайн тэмцээнийг 2 удаа зохион байгууллаа. Гурван булган жуулчны баазын дэргэд мөсөн шагайн талбай шинээр байгуулсан. Эрүүл мэндийн салбарын төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын түншлэлийг сайжруулан, зарим үзлэг шинжилгээг хувийн эмнэлгийн эмч нартай хамтран хэрэгжүүлэх зорилгоор албан байгууллагын ажиллагсадын үзлэг шинжилгээг хувийн хэвшлийн эмнэлгүүдээр хийлгэж, сумдад ХХҮХ-тэй хамтран ХХЭ-ийн шүдний эмч нарын үзлэг, шүд хийх үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлж байна. Архангай аймгийн ХХЭМБ-ын хөгжлийн 2009-2015 оны дунд хугацааны стратеги боловсруулагдав.

Хувийн эмнэлгүүдийн амбулаторийн үзлэгийн хэрэгжилт 24 хувь, урьдчилан сэргийлэх үзлэгийн хэрэгжилт 28 хувьтай байна. Эрүүл мэндийн төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр хувийн эмнэлгээр гүйцэтгүүлэх зорилтууд аймгийн ЭМС-ын дунд хугацааны хөгжлийн стратегийн баримт бичигт тусгагдав. Сум бүр ЭМД айл өрх шалгаруулах болзлыг 2003 оноос эхлэн зарлан хагас бүтэн жилээр дүгнэн урамшуулж 2009 оны байдлаар аймгийн хэмжээнд 250 айл өрх \*ЭМ-ийг дэмжигч\* айл өрх гэрчилгээг гардан аваад байна. ЭМЯ-ны 2009 оны 6 сарын 15-ний өдрийн А/184 тоот тушаалаар шинэчлэгдэн батлагдсан \*ЭМД байгууллага шалгаруулах\* болзлыг сумдад хүргүүлэн ажиллаа.

#### **4.6 Соёл урлагийн хөгжлийн бодлого**

**Стратегийн зорилт 1: Үндэсний соёлыг эрчимтэй хөгжүүлэх эдийн засаг, зохион байгуулалтын тааламжтай орчинг бүрдүүлнэ.**

Соёлын төвийн эрхлэгчийн ажлын байранд мэргэжлийн их, дээд сургуулийг бакалаврын зэрэглэлтэй төгссөн хүн ажиллуулах шалгуур тавьж ажилласнаар 13 сумын Соёлын төвийн эрхлэгч энэ шалгуурын дагуу СУИС, Соёлын дээд сургуулийг өдрөөр буюу эчнээгээр төгсөж ажиллаж байгаа нь соёл урлагийн ажил үйлчилгээ, уран бүтээлийн чанар дээшлэх нөхцөл болж байна.

Аймаг, орон нутгийн хэмжээнд 19 төрлийн 1976 соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулагдаж, урьдчилсан байдлаар давхардсан тоогоор 149.2 мянган үзэгчдэд хамрагдаж, 9.1 сая төгрөгийн үйл ажиллагааны орлоготой ажиллаж байна. Улс, аймгийн чанартай 12 төрлийн урлагийн үзлэг, уралдаан наадамд 40 гаруй уран бүтээлч, ардын авьяастан, морин хуурч, уртын дуучид оролцсон байна.

**Стратегийн зорилт 2: Хүн амд соёл, урлагийн үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэж, иргэдийн оюуны хэрэгцээг хангах талаар доривитоай ахиц гаргана.**

Үндэсний монгол бичгээ өвлүүлэн хөгжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Монгол бичгийн олимпиадыг жил бүр 11 дүгээр ангийн сурагчид болон бага, дунд ангийн багш нарын дунд зохион байгуулж шалгарсан багш, сурагчид нь улсын уралдаанд амжилттай оролцож байна.

Монголчуудын уламжлалт соёлын биет болон биет бус өвийг хадгалах, боловсролын нийтлэг хүртээл болгон дэлгэрүүлэн хөгжүүлэх зорилгоор соёлын биет

болон биет бус өвийн аймгийн бүртгэл-мэдээллийн сантай болж соёлын өвийн зүйлсийг орон нутгийн музейнд байршуулан сургалтанд өргөнөөр ашиглаж нийтийн хүртээл болгож байна.

#### **4.8 Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн бодлого**

**Стратегийн зорилт 1. Гэр бүл нийгэм хамт олонд тулгуурласан халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ.**

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэхээр төсөл сонгон шалгаруулж 9 төслийг шалгаруулан 31678,0 мян төгрөгний санхүүжилт олгон төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэ төслүүдэд 1070 иргэн хамрагдаад байна. Эдгээр төслүүдэд хамрагдан гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд 94, сэргээн засах үйлчилгээнд 80, хөдөлмөр эрхэлж, орлогын эх үүсвэртэй болоход 80 иргэн, зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулахад нийт 320 иргэд тус тус хамрагдсан. 12 сард олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 20.0 сая төгрөгний нэмэлт санхүүжилт ирж 10 суманд иргэдийг бүлгийн зохион байгуулалтанд оруулж 100 өрхийг хамруулсан байна

**Стратегийн зорилт 2. Иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгож, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.**

Орон нутгийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд үндэслэн мэргэжлийн сургалтыг хүнд машин механизмын операторч, машинист, худалдагч, касс, нярав, иргэн, зүүмэл даавуун урлал гагнуурчин, барилгын нарийн мужаан, барилгын засал чимэглэлчин, тогооч нарийн боовчин, оёдол эсгүүрчний зэрэг нийт 19 чиглэлийн сургалтанд 824 иргэнийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 79,1 сая төгрөг зарцуулсан ба үүний 65 хувь нь ажлын байраар хангагдсан байна

**Стратегийн зорилт 3. Хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт, түүний дотор нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.**

Аймгийн Засаг даргын 2009 оны 97 тоот захиармжаар “Ажилгүйдэл ядуурлыг бууруулах” аймгийн дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. 2009 онд НХХ-ийн сайд, ХХААХҮ-ийн сайдын хамтарсан 03/07 тоот тушаалын дагуу манай аймгийн Хашаат, Цэнхэр, Батцэнгэл сумдаас нийт 15 малчин өрхийг “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамруулж 30,0 сая төгрөгний мал худалдан авч өгсөн байна.

2007 оноос эхлэн албан бус хөдөлмөр эрхлэгчдийн судалгааг гаргаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, нийгмийн даатгалд хамруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2009 оны байдлаар 1755 үүнээс 1251 хувиараа хөдөлмөр эрхлэгч, 111- ажил олгогч, 68- өрхийн бизнес эрхлэгч, 268- өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч, албан ба албан бус үйл ажиллагаа эрхлэгч, 41- өрхийн бизнест цалин хөлстэй оролцогч байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд өөрсдийн хийсэн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлыг Өгийнуур,

Батцэнгэл, Өндөр-Улаан, Эрдэнэбулган зэрэг сумдад хийж Хөдөлмөрийн яармагийг олноор зохион байгуулж бизнесийн үйл ажиллагааг дэмжиж байна.

Эрдэнэбулган суманд амьдарч байгаа хөдөлмөр эрхлэгч 5 хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт, 2 хүүхдийг албан бус сургалтанд хамруулсан байна.

#### **Стратегийн зорилт 4. Нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно.**

Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо бүрдээгүй бөгөөд сонголтот тэтгэврийн тогтолцоо нь даатгуулагч 2 төрлийн тэтгэвэр авах болзол хангасан тохиолдолд аль нэгийг нь сонгон тогтоолгож байна. Нийгмийн даатгалын сангаас 13211 хүнд 11457700.0 мян төгрөгний тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь олгосон байна. Аймгийн хэмжээнд 419 аж ахуйн нэгж, байгууллагын 8866 даатгуулагч нийгмийн даатгалд хамрагдсан ба сайн дурын даатгуулагч 1217 байна. Энэ онд татварын албанд бүртгэлтэй байнгын үйл ажиллагаа явуулдаг ААН, байгууллагыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах бодлого баримтлан бүртгэл судалгааг гаргаж даатгалын хуулийн сурталчилгааг байгууллага тус бүр дээр хийж байна.

Цэргийн тэтгэвэр авдаг 118 хүн байдаг бөгөөд жилд 153.1 сая төгрөгийн тэтгэвэр олгож санхүүжилтийг улсын төсвөөс бүрэн хийж байна.

Цэргийн тэтгэвэр авдаг 118 хүн байдаг бөгөөд жилд 153.1 сая төгрөгийн тэтгэвэр олгож санхүүжилтийг улсын төсвөөс бүрэн хийж байна.

### **Тав. Эдийн засгийн өсөлт, хөгжлийн бодлого**

#### **5.1.1 Макро эдийн засгийн бодлого**

##### **5.1.1.1. Улсын төсвийн бодлого**

**Стратегийн зорилт 1.** Төсвийн төлөвлөлтийг Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд нийцүүлэн боловсронгуй болгоно.

Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг эн тэргүүнд санхүүжүүлэх зорилт тавьж төрийн албаны шинэчлэлт, төсвийн байгууллагуудыг төсвийг зөв менежментээр удирдаж арвилан хэмнэлтийн бодлогыг баримтлах чиглэлээр төсвийн байгууллагуудад зөвлөмж өгч ажиллаж байна.

Орон нутгийн төсвийн төслийг боловсруулахдаа аймгийн ЗДТГазар, холбогдох газар, хэлтэс, албад болон сумдаас төсвийн орлого, зарлагын тооцоолол, бодлогын зорилт, хөрөнгө оруулалтын арга хэмжээний санал татвар ногдох объект, орлогын холбогдох тооцоо судалгааг авч нэгтгэн, орон нутгийн төсвийн орлогыг бодитой төлөвлөх, төсвийн урсгал зардалд үнэ ханшийн өөрчлөлтийг тусгах, төлөвлөсөн зардал бодитой байх, хөтөлбөрт суурилсан арга хэмжээг санхүүжүүлэх зарчим баримталж, Монгол Улсын Засгийн газраас эдийн засаг нийгмийг хөгжүүлэх чиглэлээр баримталж буй бодлого, аймгийн Засаг

даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн үндсэн зорилт, аймгийн Иргэдийн төлөөлөгч нарын дэвшүүлсэн саналтай нягт уялдуулж, одоогийн мөрдөж буй хууль эрх зүйн орчин, эдийн засгийн хямралтай байдал, зарим төрлийн татварын хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг бодит байдалд үндэслэн хийдэг.

**Стратегийн зорилт 2.** Төсвийн хөрөнгө оруулалтыг Мянганы хөгжлийн зорилтуудтай оновчтой уялдуулан нэмэгдүүлж, **урт, дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, төслүүдэд** суурилан хэрэгжүүлнэ.

Аймгийн эдийн засаг, санхүү, төсвийн тогтвортой тэнцвэрт байдлыг хангах замаар улс, орон нутгийн төсвийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн жигд явуулахад санхүү, эдийн засгийн хүндрэлийн үр дагаварыг тооцон төсвийн орлого, зарлагын тэнцвэрт байдлыг ханган эх үүсвэртэй нь уялдуулан төсвийн байгууллагын үйл ажиллагааг бага зардлаар хэвлийн явуулж, төсөв хэмнэх зорилгоор зарим урсгал зардлыг бууруулж тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхаар зохион байгуулж ажиллаж байна.

Хөтөлбөрт суурилсан төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлж төсвийн зарлагыг эдийн засгийн бодит хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглүүлэх, зарлагын менежментийг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон, төсвийн ил тод байдлыг хангахад чиглүүлэн ажиллаж байна.

Хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг төсвийн ерөнхийлөн захирагчдаас аймагт эрх шилжүүлж өгсөн зайлшгүй хийгдвэл зохих их засвар, хөрөнгө оруулалтын ажлын эрэмбэ дарааллыг тогтоож санхүүжилт олгох чиглэл баримталж байна.

Төсвийн байгууллагуудын үйл ажиллагааг бага зардлаар оновчтой зохион байгуулах төсөв хэмнэх зорилгоор зарим урсгал зардлыг 2009 оны тодотгосон төсөвт бараа үйлчилгээний зардлыг 30,9%-иар бууруулан баталж зарлагын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

**Стратегийн зорилт 3.** Хүн амын орлого багатай ядуу болон дундаж орлоготой хэсэгт түлхүү хандсан төсвийн зарлагын бодлого хэрэгжүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын байр шинээр бий болгож нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх ажлыг оновчтой зөв зохион байгуулснаар 1628 ажлын байрыг шинээр бий болгож хөдөлмөр эрхлэлтийн албадаар зуучлуулан 1559 хүн ажилд орсон байна. Мөн нийтийг хамарсан ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг татан оролцуулж тэдний ажлын хөлсөнд 110,7 сая төгрөгийн санхүүжилтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгоод байна.

Тогтвортой амжиргаа- 2 төслийн хүрээнд олон нийтийн санаачлагын бүрэлдэхүүн хэсгийн 57 төслийг 243744,7 мянган төгрөгөөр хэрэгжүүлсэн ба 42 төслийг хэрэгжүүлэхээр санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээд байна. Бэлчээрийн мал аж ахуйн эрсдлийн удирдлага бүрэлдэхүүн хэсгийн 58 төслийг 112776,4 мянган төгрөгөөр тус тус хэрэгжүүлсэн байна.

Мерси кор олон улсын байгууллагаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор 89 иргэнд 276,4 сая төгрөгний зээлийг банкаар дамжуулан олгож барьцаа хөрөнгөгүй үйлдвэрлэл эрхлэх боломжтой иргэдэд 97,5 сая төгрөгийн зээлд хамруулсан.

### **5.1.2. Татварын бодлого**

Татварын бодлогоор экспортын чиглэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан, хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.

**Стратегийн зорилт 2.** Экологийн татварыг бий болгож, татварын суурийг өргөтгөн татвар хураалтыг сайжруулж, төсвийн орлогыг зохистой нэмэгдүүлнэ:

Татвар төлөгчдийг татвар ногдох орлого, татвар ногдох зүйлээ тодорхойлж татвараа хуулийн хугацаанд төлж хэвших талаар сургалт сурталчилгаа хийж, заавар зөвлөгөөг байнга өгч ажиллаж байна. Шинээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдэд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар заавар зөвлөгөө өгч хэвшсэнээр татвараа цаг хугацаанд нь төлж тайлагнаж байна.

Татвар ногдуулах, төлөх, тайлагнах талаар татвар төлөгчдийг гарын авлага материалаар хангаж татвараа хугацаанд нь төлж, тайлагнахыг mail, msj-ээр сануулах ажлуудыг хэрэгжүүлж байна.

Татварын хууль тогтоомжийг иргэдэд сурталчилах ажлыг нэг цэгийн үйлчилгээний байцаагч нарт хариуцуулж сургалт сурталчилгаа явуулах график төлөвлөгөөтэй ажиллаж энэ төлөвлөгөө хуваарын дагуу аж ахуйн нэгж, төсвийн байгууллага, томоохон худалдааны төвүүдийг хамруулан сурталчилгааны ажлыг явуулж байна. “Мерси Кор” төслийн байгууллага болон бусад төрийн бус байгууллагатай хамтарч бизнес эрхлэгчдэд хууль сурталчлах ажлыг зохион байгуулж байгаагаас гадна гарын авлага зөвлөмжөөр хангаж ажилласан.

Татвар төлөгчдөд татварын хууль тогтоомжуудыг тогтмол сурталчилж, татвар ногдох орлого зарлагаа үнэн зөв тодорхойлох, татварын тайлан мэдээг цаг хугацаанд гаргаж тайлагнах нөхцлийг бүрдүүлж татварын байгууллагын үйлчилгээг хөнгөн шуурхай болгох зорилгоор нэг цэгийн үйлчилгээний тасгийн байцаагч нарын ажлын цагийг өөрчлөн үдийн завсарлагын цагаар иргэдийг хүлээн авч санал сэтгэгдлийг сонсож зөвлөгөө өгдөг болов.

Татвар төлөгчийн орлого, зардлын талаархи мэдээллийг цуглуулах хөндлөнгийн эх үүсвэрүүдийг тодорхойлох, тэдгээрээс мэдээлэл цуглуулж, цугларсан мэдээллийг татварын хяналт шалгалтанд ашиглах үйл ажиллагааг сайжруулж одоогийн байдлаар 147 татвар төлөгчийн 1089 мэдээллийг цуглуулж, 40 татвар төлөгчийн 383 мэдээллийг татварын ногдуулалт төлөлт, хяналт шалгалтанд ашиглаж 14570,0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж түүнд 6427,0 мянган төгрөгийн төлбөр ногдуулсан.

Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх хөтөлбөр, Хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөр, ХХААЖДҮ-ийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Төрийн сангийн хэлтэс зэрэг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж буй газрууд болон төрийн байгууллагуудаас мэдээлэл цуглуулж, 2009 оны жилийн эцсийн татварын тайлан хүлээн авахдаа татварын ногдуулалтанд ашиглана.

Хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу 2009 онд 1009 иргэнд 75,3 сая төгрөг, 2010 онд 1081 иргэнд 101,7 сая төгрөгийг буцаан олгосон.

### **5.1.3. Мөнгө, зээлийн бодлого**

**Стратегийн зорилт 2.** Банк, санхүүгийн тогтолцоо, үйлчилгээг боловсронгуй болгоно.

Монгол Улсын Засгийн газраас 2009 оныг үйлдвэржүүлэлтийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангаас 2009 онд иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн төслийг сонгон шалгаруулах замаар 70 төсөлд 845,0 сая төгрөг, Мерси кор олон улсын байгууллагаас жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор 89 иргэнд 276,4 сая төгрөгний зээлийг банкаар дамжуулан олгож байна.

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгож үйл ажиллагааг нь дэмжсэнээр одоогоор аймгийн хэмжээнд шинээр 9 жижиг, дунд үйлдвэр байгуулагдаж 186 байнгын ажлын байр нэмэгдлээ.

Архангай аймагт бэлэн мөнгөний АТМ машин 2 байгаагын нэг нь 24 цагаар ажилладаг, аймгийн хэмжээнд 48 пос машин ажиллаж байна. Гар утасны АМАР үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийн тоо 1250 хүрсэн. Аймагт үйл ажиллагаа явуулж буй арилжааны 5 банкны 39 салбар нэгж бүгд онлайн системд холбогдон банкны үйлчилгээг харилцагч аж ахун нэгж, иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүйгээр хүргэж байна.

2009 онд ХААН банкны салбар нь Хайрхан, Булган суманд тооцооны төвийн шинэ байшин ашиглалтанд оруулж, Их тамир, Өлзийт, Чулуут,Төвшрүүлэх,Цахир сумдын банкны байранд их засвар хийж харилцагчийг тав тухай үйлчлүүлэх нөхцлөөр хангасан.

Аймагт үйл ажиллагаа явуулж буй 5-н арилжааны банкны салбар 32 тооцооны төвд Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу иж бүрэн 5, салбарын хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу хэсэгчилсэн 19, зайнаас тавьсан хяналт 15-ыг нийт 39 удаагийн шалгалтаар 3.7 тэр бум төгрөгийн зөрчлийг илрүүлэн, улсын байцаагчийн 16 мэдэгдлээр үүрэг өгч, зөрчил дутагдалд 22 актыг хууль тогтоомжийн дагуу тогтоож,1 ажилтанд 100000 төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил дутагдалыг бүрэн арилгуулан ажиллаа.

2009 оны жилийн эцсийн байдлаар нийт 29415,5 сая төгрөгийн зээл олгож, 30152,2 сая төгрөгийн зээл төлүүлж, зээлийн багц 19625,4 сая төгрөгт хүрсэн. Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 2.4 байна. Зээлийн эргэн төлөлт 95.1%

Олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,9 тэр бум төгрөг буюу 23,2 %-иар, зээлийн чанар 3,2 %-иар, зээлийн эргэн төлөлт 4,4 тэр бум төгрөг буюу 12,7 %-иар тус тус буурсан байна. Монгол банкны салбараас банкны зээл олголт зээлийн эргэн төлөлтөнд тавих хяналтыг сайжруулсны үр дүнд чанаргүй зээл Хангайн бүсийн аймгуудын банкны чанаргүй зээлийн дундажаас 2,9 пунктээр бага байна.

**Стратегийн зорилт 3.** Зээлийн хүүг бууруулж, хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчин бүрдүүлнэ:

2009.11.30-ны байдлаар нийт 26815.8 сая төгрөгийн зээл олгож, 27352.4 сая төгрөгийн зээл төлүүлж, зээлийн багц 19825.9 сая төгрөгт хүрсэн. Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь 2.1 байна. Зээлийн эргэн төлөлт 95.1% Олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9,6 тэр бум төгрөг буюу 2,6 %-иар, зээлийн чанар 1,4 %-иар, зээлийн эргэн төлөлт 3,6%-иар тус тус буурсан байна. Энэ нь эдийн засгийн хямрал болон тооцоо судалгаагүй зээл олгосон, мөн иргэд өөрсдөө орлогоос давсан зээл авсантай холбоотойгоор нийт зээлд эзлэх чанаргүй зээл өмнөх мөн үеэс 1.5 пунктээр өссөн дүнтэй байна.

## **5.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого**

### **Монгол Улсын хөгжлийн 3 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээнд:**

Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийг Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг түргэтгэх, мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгоход чиглүүлнэ. Дотоодын нийт бүтээгдэхүүнд үйлчилгээ, аж үйлдвэрийн салбарын хувийн жинг тууштай нэмэгдүүлж, 2015 онд 85 хувьд, 2021 онд 92 хувьд хүргэж, дундаж хөгжилтэй орнуудынхтай ижил эдийн засгийн бүтцийг бий болгоно.

#### **5.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого**

**Стратегийн зорилт 1.** Стратегийн орд газруудыг ашиглана. Улсын зардлаар геологийн хайгуул хийж, нөөцийг нь тогтоосон стратегийн орд газруудад төрийн мэдлийн хувийг 51-ээс дээш байлгах бодлогыг баримтална:

*Орон нутагт нүүрсний болон эдийн засгийн үр ашигтай эрдэс баялагийн эрэл хайгуулын ажлыг улсын төсвийн болон гадаад дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн оролцоотойгоор хийх ажлыг өргөтгөх.*

*Улсын болон орон нутгийн чанартай авто замын байгууламжуудын чанарыг сайжруулах, нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэх ажилд жилд дунджаар 350-аас доошгүй сая төгрөг зарцуулж байна.*

**Стратегийн зорилт 1.** Гадаад зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ:

*Бүс нутгийн эрэлт нийлүүлэлтэнд тулгуурлан өрсөлдөх чадвар бүхий бүс, орон нутгийн хэрэгцээг хангах оёдол, нэхмэл сүлжмэлийн бага, дунд үйлдвэрийг байгуулах төсөл, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна.*

**Стратегийн зорилт 2.** Бүс нутгуудын хөгжлийн дотоод, гадаад нөөц боломжтой оновчтой уялдуулан **үйлдвэрлэл, технологийн паркуудыг** байгуулж хөгжүүлнэ:

*Өндөр технологид түшиглэсэн шинэ сортын төмс, хүнсний ногооны үр тарианы үйлдвэрлэлийг өргөжүүлж, орон нутгийн хэрэгцээг хангахын зэрэгцээ хөрш зэргэлдээ аймаг бүс нутгийн хэрэгцээг хангах хэмжээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.*

### **5.2.1.3. Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийн бодлого:**

Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах таатай орчин бүрдүүлнэ.

*Аймгийн хэмжээнд хөгжүүлж болох жижиг, дунд үйлдвэрийг судлан хөтөлбөр, чиглэлийг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр батлуулан ажиллаж байна.*

*Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин төсөл сонгон шалгаруулах замаар 2009 онд 70 төсөлд 845,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгоод байна. Энэ хүрээнд шинээр 9 жижиг, дунд үйлдвэр, цех байгуулагдаж, 186 байнгын ажлын байр нэмэгдэнэ. Төсөл боловсруулах, үйлдвэрлэл хөтлөн явуулах сургалтанд нийт 1800 гаруй иргэдийг хамруулж сургалтанд хамрагдсан иргэдийн 70% нь ажлын байраар хангагдсан байна.*

*Хөнгөлөлттэй зээлийн хүрээнд сүү, цагаан идээ, талх нарийн боов, хүнсний ногоо, барилгын материалын үйлдвэрлэл, мал аж ахуйн фермер, оёдлын чиглэлийн төслүүд хэрэгжиж байна.*

*Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 19 сумын 118 иргэн, 6 ААНэгжид нийт 261,7 сая төгрөгний хөнгөлөлттэй зээлийг олгосноор 435 тогтмол ажлын байр, Хөдөөгийн Агробизнесийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд зарим сумдад түүхий эд бэлтгэн ниилүүлэх, боловсруулах чиглэлээр үйлдвэрлэгчдийн 23 малчны бүлэг байгуулан 32,0 сая төгрөгний хөнгөлөлттэй зээл олгосны үр дүнд нийт 1575 ажлын байр шинээр бий болсны 28,5 хувь боловсруулах үйлдвэрлэлд, 20.3 хувь нь ХАА-н салбарт, 11.9 хувь нь бөөний болон жижиглэнгийн худалдаа үйлчилгээний салбарт бий болсон байна.*

**Стратегийн зорилт 1.** Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ:

*Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээлийн баталгаа гаргах, зээлийн даатгалын үйлчилгээнд хамруулах талаар хуулиудад өөрчлөлт оруулах тухай саналаа холбогдох газруудад хүргүүлэв.*

*Мерси кор олон улсын байгууллагаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор 89 иргэнд 276,4 сая төгрөгний зээлийг банкаар дамжуулан*

*олгож барьцаа хөрөнгөөгүй үйлдвэрлэл эрхлэх боломжтой иргэдэд 97,5 сая төгрөгний баталгаа гарган өгч зээлд хамруулав.*

**Стратегийн зорилт 2.** Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно:

*Үйлдвэрлэгчдэд зориулсан сургалтыг орон нутагт жил бүр үе шаттайгаар явуулж, “Нэг-Цонх”-ны үйлчилгээг нэвтрүүлэн жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, төсөл боловсруулах аргачлалын талаар зөвлөгөө өгөх, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнд “Ажил олгогч эздийн холбоо”, “Хоршоологчдын холбоо” зэрэг мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулан шийдвэрлэж байна.*

#### **5.2.1.4. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн хөгжлийн бодлого**

*Хөдөө аж ахуй, хүнсний салбарын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эрсдэл даах чадавхийг бэхжүүлэх замаар орчин үеийн **хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн цогцолбор** болгон хөгжүүлж, хүн амын гурил, мах, сүү, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, хүртээмж, чанар, эрүүл ахуйн аюулгүй байдлыг сайжруулна.*

**Стратегийн зорилт 1.** Бүс нутгийн онцлогыг харгалзан бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, халдварт өвчний гаралт, тархалтыг эрс бууруулан малыг эрүүлжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалт, экспортыг нэмэгдүүлнэ:

*Мал эмнэлгийн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж мал эмнэлэг-ариун цэврийн шинжилгээ хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж, эм урвалжаар хангаж мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнд тавих эрүүл ахуйн хяналтыг сайжруулж аймгийн хэмжээнд худалдаа үйлчилгээ үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулж буй 138 аж ахуйн нэгж, цэг салбарт хүнсний аюулгүй байдлын хяналт шалгалт хийж, чанар стандартын шаардлага хангахгүй 20 гаруй бүтээгдэхүүний зөрчил дутагдлыг илэрүүлж зохих арга хэмжээ авсны зэрэгцээ архи худалдаалах дэлгүүр цэг салбарыг аттестатчлах арга хэмжээ авч цаашид энэ талаар баримтлах бодлогыг тодорхойллоо.*

*Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүлжүүлэх хавар, намрын арга хэмжээг зохион байгуулж 1.2 сая толгой малыг халдварт өвчнөөс, 1.0 сая толгой малыг паразиттах өвчнөөс сэргийлж 152.0 сая төгрөг зарцуулсан байна.*

*Малын чанар сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж “Тамир”, “Хотонт” хонинд үзлэг ангилалт хийж цөм сүргийг бүрдүүлэн хянан баталгаажуулалтыг 12 сумын 25000 бог малд хийлээ.*

*Шилмэл омог хэвшлийн мал үржүүлэх, өндөр ашиг шимтэй сүү, махны чиглэлийн үхрийн фермерийн аж ахуй байгуулах төслийг сонгон шалгаруулж 6*

иргэн, аж ахуйн нэгжид 110,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгон дэмжлэг үзүүлэв.

*Цөм сүргийн үржлийн төвийг байгуулан Сэлэнгэ үүлдрийн 18 үхэр, илүү нуруу нугаламтай 500 гаруй хонь бүхий үржлийн цөм сүргийг бүрдүүлэн үйл ажиллагаа явуулж байна. “Тамир”, “Сэлэнгэ” үүлдрийн хэсгийн хонь, үхрээр цөм сүргээ бүрдүүлж 11 сумын 75 өрхөд сайн чанарын нутгийн омгийн хургатай хонь 375 ыг олгож 30,0 сая төгрөг зарцууллаа.*

*Өндөр-Улаан сумыг аймгийн хэмжээнд бэлчээр ашиглалтын загвар сум болгохоор тогтвортой амьжиргаа -2 төслөөс 15000 ам. долларын ажил хийгдэж эхлээд байна.*

*Малчдын бүлэг байгуулж бэлчээр ашиглалт, мал аж ахуй эрхлэх, шинжлэх ухааны олтыг нэвтрүүлэх, таниулах төрөл бүрийн сургалтыг зохион байгуулах ажлыг засаг захиргааны нэгж бүрээр зохион байгуулан хэвшиж сургалтын нээлсэн тогтолцоог бий болгов.*

**Стратегийн зорилт 2.** Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлэн, биотехнологи нэвтрүүлэн газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ:

*2009 онд газар тариалангийн салбарыг хөгжүүлэх “Атрын 3 дахь аян” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 4000 га талбайд үр тариа тариалж 2305 тн улаан буудай, 770.5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж 4386 тн ургац хураан авлаа.*

*Хураан авсан үр тарианы хэмжээ урьд оныхоос 22 хувиар өссөн дүн гарч байна. Сум бүрт 120 м<sup>2</sup> талбай бүхий хүлэмж, 30 тн багтаамжтай зоорийг барьж, бага оврын трактор, төхөөрөмж бүхий агропаркийг байгуулснаар орон нутгийн хамгаалагдсан хөрсний тариаланг хөгжүүлэх үндэс суурийг тавьлаа.*

*Энэ онд 39,5 га-д тэжээлийн нэг наст ургамал тариалж 435 тн ургац авлаа. Цаг агаар хүндэрсэн үед хэрэглэх тэжээлийн аюулаас хамгаалах нөөцийн байрыг Тогтвортой амьжиргаа-2 төслийн хүрээнд Эрдэнэмандал суманд барихад зориулж 21,0 сая төгрөг, нөөцийн өвс, тэжээл бэлтгэх 100,0 сая төгрөгийн асуудлыг хөдөөгийн ядуурлыг бууруулах хөтөлбөрт тавьж хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх шатанд байна.*

**Стратегийн зорилт 3.** Хүнсний үйлдвэрлэлд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулна:

*Экологийн цэвэр бүтээгдэхүүн боловсруулах технологийн горим бүхий хүнсний ногоо боловсруулах “Цех”-ийг хүнсний ногооны нөөц бүхий сумдад байгуулах ажлыг зохион байгуулж, төмс хүнсний ногоо нөөшлөх, савлагаатай төмс, хүнсний ногоо нийлүүлэх, талх, нарийн боов, мах борцлох, төслүүдийг дэмжиж 16 иргэн, аж ахуйн нэгжид 320,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгож дэмжлэг үзүүлэв.*

*Мах бэлтгэн экспортлох чиглэлээр махны үйлдвэрийг шинээр ашиглалтанд оруулав.*

**Стратегийн зорилт 4.** Газар тариалангийн болон бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, хөдөөгийн хүн амын ундны усны хэрэгцээ, шаардлагад тохирсон усны нөөцийг нэмэгдүүлнэ:

*Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж инженерийн хийцтэй худаг 15-ийг шинээр гарган, 19 суманд 150 гаруй булаг шандны эхийг хамгаалж хүн, малын ундны усны хүрэлцээг нэмэгдүүлэх арга хэмжээ авлаа.*

**Стратеги зорилт 5.** Малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлж, тэжээлийн шимт чанар, тэжээллэг байдлыг сайжруулах, хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

*Малын тэмжээлийн ургамал тариалах га-гийн хэмжээг жил бүр нэмэгдүүлж Эрдэнэбулган, Төвшрүүлэх, Хайрхан сумдад тэжээлийн үйлдвэр байгуулах санал санаачлагыг дэмжиж хөнгөлөлттэй зээл, төсөл, хөтөлбөрт хамруулах ажлыг хийж байна.*

#### **5.2.1.5. Аялал жуулчлалын хөгжлийн бодлого**

**Стратегийн зорилт 1.** Жуулчин тээвэрлэх болон жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж, аялал жуулчлалын гол бүс нутгийн зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулна.

*Хар хорин-Хөшөө цайдам, Өгийнуур чиглэлийн 55 км хатуу хучилттай зам ашиглалтанд орсон.*

*Хорго тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолбор газрын дэд бүтэцийг хөвсгөл аймгийн аялал жуулчлалын сүлжээнд холбох ажлыг өргөжүүлнэ.*

**Стратегийн зорилт 2.** Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг барьж байгуулан, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын төрлүүдийг бүс нутгаар төрөлжүүлэн хөгжүүлнэ.

*Байгаль хамгаалал, экотуризм, аялал жуулчлалыг хөгжүүлэх үйл ажиллагаанд ард иргэдийг өргөн оролцуулсан хамтын менежментийг боловсронгуй болгохоор аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөг ИТХТ-ээр хэлэлцүүлж батлуулах ажлыг зохион байгууллаад байна.*

*Экотуризмыг хөгжүүлэх үндэс болсон рашаан, байгалийн цогцолборт газрын судалгааг гарган зарим рашаан, рашаан төст булгийн усны дээж шинжилгээг мэргэжлийн байгууллагаар судлуулан батлагдсан усаар иргэдэд үйлчлэх нөхцлийг бүрдүүлж рашаан усны тооллогыг аймгийн хэмжээнд хийж бүх рашааны дээжээс сорьц авч Усны газарт хүргүүлж шинжлэн судлуулж байна*

*Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй жуулчны бааз, эко гэрүүдийн судалгаа гаргаж жуулчны баазуудад аймгийн Засаг даргын албан даалгавар хүргүүлээд байна.*

*Архангай аймагт аялал жуулчлалын 23 бааз үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр баазууд жилдээ гадаад дотоодын 10 гаруй мянган жуулчин хүлээн авч үйлчилж байна.*

### **5.3. Дэд бүтцийн хөгжлийн бодлого**

#### **5.3.1. Зам, тээврийн хөгжлийн бодлого**

**Стратегийн зорилт 1.** Зам, тээврийн салбарын хөгжлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгоно:

*Мянганы замын хэвтээ тэнхлэгийг барьж дуусгах буюу аймгийн төвийг Улаанбаатар хотын хатуу хучилттай замаар холбох ажил хийгдэж байна. Дээрх ажлын хүрээнд Хархорин-Цэцэрлэгийн чиглэлийн 116.06 км хатуу хучилттай, Цэцэрлэг-Тосонцэнгэлийн чиглэлийн 218.2 км хатуу хучилттай замуудыг тус тус барьж эхлээд байна*

#### **5.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого**

**Стратегийн зорилт 1.** Монгол Улсын “**Эрчим хүчний нэгдсэн систем**”-ийг байгуулж, эрчим хүчний салбарын ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэн, хөгжлийн нэн таатай орчинг бий болгоно. Эрчим хүчний салбарыг эрчим хүч экспортолдог чадамжтай болгоно:

*Сум, суурин газрын эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагааг хангах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийн зэрэгцээ эрчим хүчний алдагдлыг бууруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж шугам сүлжээ, тоног төхөөрөмжид шинэчлэл хийнэ*

*Аймгийн төв болон сум, суурин газруудад дулаан хангамжийн шинэ эх үүсвэр барих ажлуудыг сонирхогч гадаад дотоодын төсөл, хөтөлбөрөөр хэрэгжүүлэх ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах ажлыг хийнэ*

**Стратегийн зорилт 2.** Сум, суурин газрын болон малчдын цахилгаан эрчим хүчний хангамжийг сайжруулна:

*Малчдын өрхийн 80-аас доошгүй хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах ажлыг 2014 он гэхэд хийж дуусгана*

#### **5.3.3. Түлшний салбарын хөгжлийн бодлого**

**Стратегийн зорилт 1.** Нүүрс хийжүүлж, бага оврын цахилгаан станцуудыг түлшээр хангана:

*Аймгийн төв болон томоохон сум, суурин газруудын хэрэглээг хийн түлшинд ээлж дараатай шилжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхлэнэ*

#### **5.3.4. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн бодлого**

**Стратегийн зорилт 1.** Мэдээлэл харилцааны технологийн салбарын программ хангамж, технологи, эрх зүй, бүтэц, зохион байгуулалт, санхүү, эдийн засгийн болон хүний нөөцийн нэн таатай орчинг бүрдүүлнэ:

*Аймгийн төв болон томоохон сум, суурин газруудын хэрэглээг хийн түлшинд ээлж дараатай шилжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхлэнэ*

**Стратегийн зорилт 2.** Мэдээлэл харилцааны технологийн ололтыг нийгэм, эдийн засгийн бүх салбарт өргөн нэвтрүүлнэ:

*Аймгийн төв болон томоохон сум, суурин газруудын хэрэглээг хийн түлшинд ээлж дараатай шилжүүлэх ажлыг хэрэгжүүлж эхлэнэ*

#### **5.3.5. Хот байгуулалт, барилгын хөгжлийн бодлого**

**Стратегийн зорилт 1.** Хүн амын нутагшилт, суурьшлын зохистойтогтолцоог хөгжүүлж, хот, суурингийн оршин суугчдад таатай орчин бүрдүүлнэ.

*Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу орон нутгийн хөгжлийн сумдын тулгуур төвүүдийг тодорхойлох асуудлыг судлан хэрэгжүүлнэ.*

**Стратегийн зорилт 2.** Орчин үеийн чанарын шаардлага бүхий барилга, шинэ нэр төрлийн барилгын материалын үйлдвэрлэл, нийтийн аж ахуйн салбарыг бий болгон хөгжүүлнэ:

*Аймгийн төвийн гэр хорооллыг цэвэр бохир усны системд холбох ажлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ бүх сумдад эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усны эх үүсвэрүүдийг бий болгоно*

**Стратегийн зорилт 3.** Хүн амын орон сууцны хангамжийг эрс сайжруулна. **“Орон сууц” үндэсний хөтөлбөр** хэрэгжүүлнэ:

*Аймгийн төвийн болон бүх сумдын хүн амын орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. Тэдгээрт шаардлагатай инженерийн дэд бүтцийг барьж байгуулах ажлыг нэмэгдүүлнэ*

*Хотын доторхи зам талбайн гэрэлтүүлэг тохижилтыг сайжруулж эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.*

#### **5.4. Бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн бодлого**

**Стратегийн зорилт 1.** Бүсчилсэн хөгжлийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгож, бүс нутгийн хөгжлийг түргэсгэнэ:

*Хангайн бүсийн хөгжилд Архангай аймгийн үзүүлэх нөлөө, эзлэх байр суурийг бэхжүүлэх зорилгоор мянганы хөгжлийн зорилтуудыг үндэслэн 2006-2015 он хүтэлх аймгийн хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан ИТХ-аар хэлэлцэн батлаж жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлж байна.*

## **Зургаа. Байгаль орчны бодлого**

**Стратегийн зорилт 1.** Байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсооно:

*Хуурай хог хаягдалын менежментийг сайжруулах ажлын хүрээнд хог тээврийн 5 машинаар айл бүр сар болгонд хүрч үйлчилдэг болсноор хуурай хог хаягдал нэгдсэн хогийн цэгт төвлөрч байна.*

*Аж ахуйн нэгж, байгууллагыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөтэй ажиллуулснаар хаягдал бохирдлын стандартыг мөрдүүлж хэвшүүлэх ажлыг зохион байгуулсанаар 70 орчим хувьтайгаар хэрэгжиж байна.*

**Стратегийн зорилт 2.** Газар, газрын хэвлийн баялагийг зохистой ашиглах нэгдсэн бодлого хэрэгжүүлнэ:

*Аймгийн хэмжээнд байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газар ойн сан, усан сан бүхий газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах ажлыг зохион байгуулж эрчимжүүлж байна.*

**Стратегийн зорилт 3.** Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцөлийг бүрдүүлнэ. **“Ус” үндэсний хөтөлбөр** хэрэгжүүлнэ:

*Нийт 14 сумын ус ашиглагч аж ахуй нэгж байгууллагуудын ус ашиглалтын болон хөдөө аж ахуйн усны хэрэглээг гарган гео мэдээллийн сан бүрдүүлж, усны ашиглалт зарцуулалтын дүгнэлтийг гаргаад байна.*

*Бүх нийтээр ус хэмнэлтийг өрнүүлэх ажлын хүрээнд аймгийн төвийн айл өрхийн ундны усыг тоолууржуулж цэвэр усыг хэмнэлттэй зарцууладаг болсон.*

**Стратегийн зорилт 4.** Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцөлийг хангана:

*Ой зохион байгуулалтын шинэчилэн боловсруулсан зураглалд үндэслэн ойжуулах, ойн арга хэмжээний бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гарган хэрэгжүүлж, ойжуулалтын ажилд байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн оролцоог нэмэгдүүлж эхлээд байна.*

*Мод бэлтгэл явагдсан, ой хээрийн түймэрт өртсөн, хортон шавьжинд нэрвэгдсэн газрын судалгааг гаргаж, талбайн хэмжээг тогтоон, улсын төсвийн хөрөнгөөр 214 га-д аж ахуй нэгж байгууллагын хөрөнгөөр 80 га-д нийт 294 га талбайд ойжуулалтын ажил хийгдсэн.*

*Навчит модноос хайлаас, шар хуйас, чацаргана, улиас зэрэг модны тарьц зэрэг мод бут сөөг 3000 гаруйг тарьж ургуулаад байна.*

*Ой зохион байгуулалтын ажлыг ой бүхий 16 сумыг хамруулан 1008613 га-д хийж гүйцэтгэсэн. Хүлэмжинд 10 гаруй мянган тарьц суулгац ургаж байна.*

*Ойн хортон шавьжийн судалгааг ой бүхий сумдаар ойн хайгуул судалгааны төвтөй хамтран шат дараатайгаар бүсчлэн ойн хортонтой тэмцэх тэмцлийн ажлыг 14000 га-д хийж гүйцэтгэсэн*

*Ойн сан бүхий газрыг нутгийн иргэд, ойн нөхөрлөлүүдэд гэрээгээр эзэмшүүлэх бэлтгэл ажил хангагдаад байна.*

*Хашаат, Хотонт сумдын зарим ойн нөхөрлөлд 1000 ширхэг улиасны суулгац тарих зааврын хамт өгч тариулах арга хэмжээ авч эхэлсэн бөгөөд навчит модны үрийг мод үржүүлгийн газар тариад байна*

**Стратегийн зорилт 5.** Амьтан, ургамлын аймгийн нөөцийн хомсдолыг хязгаарлаж, тэдгээрийг байгалийн жамаар нөхөн сэргэх, тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ:

*Говь хээрийн болон цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд унаган ургамлыг тарималжуулах, хур тунадас нэмэгдүүлэх, ус хуримтлуулах, хиймэл нуур цөөрөм байгуулах замаар экосистемийн тэнцвэрт байдлыг хангах арга хэмжээ авч ажиллаж байна.*

*Амьтан ургамлын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах менежментийг сайжруулж, тэдгээрийн байгалийн жамаар өсөж үржих, нөхөн сэргээх таатай нөхцөлийг бүрдүүлж, амьтдыг хамгаалах, өсгөн үржүүлэх зорилгоор био техникийн ажил зохион байгуулсан.*

## **Долоо. Эрх зүй, төрийн байгуулалын хөгжлийн бодлого**

### **7.1. Эрх зүйн шинэчлэл**

**Стратегийн зорилт 1.** Төрийн үйлчилгээг хүртээмжтэй, ил тод болгох, иргэд төрийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, төрийн байгууллагын үйл ажиллагааг иргэдэд сурталчилах ажилд анхаарлаа хандуулж ирлээ. Энэ ажлын хүрээнд “Хүний эрхийн судалгааны төв”-тэй хамтран Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүгийн дэмжлэгтэйгээр тусгай өрөө гарган тохижуулж холбогдох техник хэрэгсэлийг суурилуулан “Нэг цонх”-ны үйлчилгээг 2009 оны 7 дугаар сараас нээн ажиллуулж байна.

“Нэг цонх”-ны үйлчилгээ нэвтэрсэнээр иргэд төрийн үйлчилгээг чирэгдэлгүй авах боломж бүрдэж өдөрт дунджаар 80 иргэнд нийгмийн халамж, иргэний бүртгэл, нийгмийн даатгал, газрын харилцааны чиглэлээр төрийн үйлчилгээг хүргэж банк, нотариат зэрэг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Сум бүрт хүн ам, өрхийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлж компьютерт шивэн ашигладаг болсноор иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөн зэрэг бүртгэлийн үйлчилгээг нэг цэгээс шуурхай авах боломж бүрдсэн байна.

Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд багийн төв барих, засварлахад зориулж орон нутгийн төсөв болон бусад гадаадын санхүүжүүлэгч байгууллагатай хамтран 131.5 сая төгрөгийг зарцуулж 27 багийн төвийг тохижуулаад байна. Эрдэнэмандал, Хашаат, Цахир, Жаргалант, Цэцэрлэг сумдын

алслагдсан багуудад “Инкрмнет”-ийн холбоо тавьснаас гадна баг бүр Ямаха хөгжим, Ямаха мотороор бүрэн хангагдсан юм.

Багийн төвд багийн Засаг дарга, хүний эмч, байгаль хамгаалагч зэрэг албан хаагчдыг байнга байршуулах шаардлага тавин ажилласнаар хөдөөгийн иргэд чирэгдэлгүй нэг цэгийн үйлчилгээ авч эхэлж байна. Хөдөөгийн багийн 60 гаруй хувь нь багтаа төвлөрөн ажиллаж байна.

Төрийн байгууллагын үзүүлж буй үйлчилгээ, орон нутгийн түвшинд хийж хэрэгжүүлэх ажил, тулгамдсан асуудал түүнийг хэрэгжүүлэх арга замын талаар иргэдтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах, төрийн үйлчилгээг хүргэх үүднээс сум, байгууллага бүр улирал тутамд нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж хэвшсэн байна.

## **Стратегийн зорилт 2. Хүний эрхийг баталгаатай хангана.**

Хүний эрхийг хангах аймгийн салбар хороо байгуулагдан үйл ажиллагаа нь явагдаж байгаа ба 2009 онд тус салбар хороо нь 3 удаа хуралдаж сум, байгууллагад зөвлөмж, чиглэл өгөн тэдний хийж ажлыг эрчимжүүлэхэд анхааран ажиллаж иржээ. 2010 онд хүний эрхийн талаар явуулах үйл ажиллагаанд хөрөнгө гаргаж шат дараалсан арга хэмжээнүүдийг эхнээс нь авч хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хязгаарлагдмал боломжинд тулгуурлах, тэднийг чөлөөтэй саадгүй зорчих боломжийг бүрдүүлэх үүднээс шинээр баригдаж байгаа болон засварлаж байгаа зам талбай, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, нийтийн үйлчилгээний газрын орц, гарц хүн зорчих хэсгийг тэдэнд тусгайлан зориулж засварлаж тохижуулах бодлого барьж ажиллаж байна.

Одоо байгаа барилга байгууламж, нийтийн үйлчилгээний газарт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн тусгай зам, талбай бий эсэхэд үнэлгээ хийх зорилгоор аймгийн Засаг даргын 2009 оны 139 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулан ажиллуулахад налуу замтай 7 үүнээс шаардлага хангасан 2, стандарт хангаагүй 00 өрөө 29, хаалганы стандарт хангаагүй 29, гаднаа налуу замгүй шат нь өндөр 23 байгууллага байсан ба тухайн байгууллагын дарга нартай уулзаж боломжиндоо тохируулж зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг анхаарууллаа.

Энэ ажлын хүрээнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс налуу замаа стандартын болгож, 9 байгууллага шинээр налуу зам хийсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлж аймгийн нийтийн худалдааны төв дээр бараа, хүнсний тус бүр 1 лангууны түрээсийн төлбөрийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс төлж үйл ажиллагааг нь жигдрүүлжээ.

Хүүхдийн эрхийг хангах, тэдэнд чиглэсэн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүднээс “Хүүхэд” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын шийдвэрээр байгуулан төрөл бүрийн судалгааны ажлуудыг хийж эхлээд байна. Үүнд хүүхдийн асуудлаарх нөхцөл байдлын судалгааг 12

байгууллагаас авч мониторинг хийж байна. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бодит мэдээллийг авах судалгааг Эрдэнэбулган, Батцэнгэл, Тариат сумын судалгаанд хамрагдвал зохих нийт 3687 хүүхдээс одоогийн байдлаар 2700 хүүхэд хамрагдаж судалгааны боловсруулалт, тайлангийн ажил хийгдэж дууслаа.

### **Стратегийн зорилт 3.Нийгэм дэх аюулгүй орчныг бий болгох эрх зүйн орчныг боловсронгуй болгох**

Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах үүднээс аймгийн хэмжээнд сүүлийн 10 жилд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг гарч байгаа хэрэг, зөрчлийн төрөл, тархалт үйлдэгдэж байгаа газар, цаг хугацаа, нутаг, үйлдсэн арга, шалтгаан, гэмт хэрэгт оролцсон байдал, ашигласан багаж хэрэгсэл гэмт хэргийн улмаас учирсан хохирлын судалгааг гаргаж, аймаг орон нутгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд оны эхнээс үнэлэлт дүгнэлт хийж Эрдэнэбулган сум болон хүн ам олноор сууршсан суманд эргүүлийн хүчийг оновчтой хуваарилж, цаг үеийн нөхцөл байдалд тохирсон нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, хөдөлгөөнт эргүүлийг хяналтын цэгүүдэд чанартай зохион байгуулан аймгийн хэмжээнд гудамж талбай олон нийтийн газар болон согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан дүгнэлт хийж, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагч нарыг үүрэгжүүлэн, хэсгийн байцаагч, багийн цагдаа нарыг 14-22 цаг хүртэл хариуцсан багт ажилуулж, 20-01 цаг хүртэл хэв журмын эргүүл, 21-09 цаг хүртэл шөнийн эргүүлд алба хаагч нарыг томилон эмзэг цэгүүдэд хяналт тавьж ажилласанаар гудамж талбай олон нийтийн газар үйлдэгдсэн гэмт хэрэг 3 буюу 7%, үйлдэгдэж байгаа гэмт хэрэг 53 буюу 33 хувиар, зөрчил 73 буюу 19 хувиар тус тус буурсан байна.

2009 онд нийт 416 гэмт хэрэг үйлдэгдсэнээс 311 гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлсэн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн улмаас ард иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжид 87,877,000 төгрөгний хохирол учирснаас 61,595,000 төгрөгний хохирлыг нөхөн төлүүлсэн нь 70,1 хувьтай байна. Хохирол төлөгдөөгүй гэмт хэрэгт 149,900 төгрөгний хөрөнгө битүүмжлэх ажиллагаа хийсэн байна.

### **7.3. Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны шинэтгэлийн бодлого**

#### **Стратегийн зорилт 1.Төрийн албаны стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг хөгжүүлнэ.**

Засгийн Газрын 2008 оны 67 дугаар тогтоолын дагуу нутгийн захиргааны байгууллагын бодлого боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийн зохион байгуулж, зохицуулах үйл ажиллагааны үе шатаар хийх, хяналт шинжилгээ, үнэлгээний цар хүрээг өргөжүүлж үр нөлөөг сайжруулах зорилгоор Хяналт шинжилгээ үнэлгээний тасаг байгуулан ажиллуулж байна.

ХШҮ-ий тасгаас 8 агентлагийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг удирдамжийн дагуу хийж, дүгнэлт өгч, газар дээр нь зөвлөмж өгч ажилласан.

18 суманд аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг хийж, сум, агентлагуудад Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн Газраас баталсан үндэсний хөтөлбөрүүд, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах талаар зохиож буй ажлыг газар дээр нь шалган зөвлөх ажлыг зохион байгуулсан.

Аймгийн Засаг даргын Тамгын Газар, хэлтэс, тасаг, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудаас санал захиалга авч зохицуулалт хийн нэгдсэн хуваарь боловсруулан Засаг даргаар батлуулан мөрдөж 2009 онд төрийн байгууллагын албан хаагчдын дунд 39 удаагийн сургалт семинар, зөвлөлгөөнийг аймагт зохион байгуулж давхардсан тоогоор 1450 гаруй албан хаагч оролцсон байна.

Хашаат, Өгийнуур, Хангай, Цахир, Хотонт сумдын Засаг даргын Тамгын Газрын дарга, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, Тээвэр авто замын газрын даргын сонгон шалгаруулалтыг хэвлэл мэдээллээр зарлан явуулж, тэнцсэн иргэдийг удирдах ажилтны нөөцөд бүртгэн нэр дэвшүүлж, томилгоо хийлгүүлэв.

Сумдын Засаг даргын Тамгын Газар, хэрэгжүүлэгч агентлагуудаас Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалга авч нэгтгэн Төрийн албаны зөвлөлөөр дамжуулан төвийн хэвлэл, вэб сайтаар нийтэд мэдээлж, төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 3 удаа зохион байгуулан явуулж төрийн захиргааны албан тушаалын нөөцөд 161 иргэн бүртгэгдсэнээс 46 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулав.

**Стратегийн зорилт 2.Төрийн албаны бодлого, дүн шинжилгээний болон төрийн албан хаагчийн манлайллын чадамжийг шинэ түвшинд хүргэнэ.**

Төрийн албаны зөвлөлд ажлын байрны захиалга хүргүүлэн аймгийн Засаг даргын Тамгын Газрын даргын албан тушаалд өрсөлдөх ажилтны сонгон шалгаруулалтыг Төрийн албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулав. Төрийн албаны салбар зөвлөлд Хангай, Цахир, Өгийнуур, Хашаат, Хотонт сумдын Засаг дарга нараас ирүүлсэн захиалгын дагуу дээрх сумдын Засаг даргын Тамгын Газрын даргын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулах ажлыг нийтэд ил тод зарлан нээлттэй өрсөлдөөний зарчмаар явуулан сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалын шалгалтад тэнцсэн 14 иргэдийг онооны дарааллаар сумын Засаг даргын Тамгын Газрын даргын нөөцийн жагсаалтад бүртгэн Төрийн албаны тухай хуулийн 17.3 дахь заалтын дагуу тухайн ажлын байранд хамгийн өндөр оноо авч нэгээр гарсан иргэдийг Тамгын Газрын даргын албан тушаалд ажиллуулахаар нэр дэвшүүлсэн.

Зарим агентлагийн бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын, тээвэр авто замын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг нээлттэй өрсөлдөөний зарчмаар нийтэд ил тод зарлан явуулж, тэнцсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан Ч.Отгонжаргалыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын,

Ж.Гурвантамирыг Тээвэр авто замын газрын даргад нэр дэвшүүлэн томилгоо хийлгүүлэв.

### **Стратегийн зорилт 3. Байгууллагын болон хүний нөөцийн хөгжлийг хангана.**

Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2009 онд Хашаат, Өгийнуур, Батцэнгэл, Хотонт, Цахир, Хангай, Тариат сумдын төсвийн байгууллагын менежер 42 ажилтныг удирдах ажилтны манлайлах ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулан сургаж.

Шинээр бэлтгэгдэж байгаа манлайллын сургалтын мастер сургагч багшийн сургалтад аймгийн Эрүүл мэндийн газрын орлогч дарга Р.Гандиймааг суралцуулан семинарт бүрэн оролцох, дадлага даалгавраа гүйцэтгэх боломжоор хангах, орон нутагт зохион байгуулсан мастер сургагч багшийн сургалтад биечлэн оролцуулж дадлагажуулахад дэмжлэг үзүүлээ.

Төрийн байгууллагууд боловсон хүчний хэрэгцээний төлөвлөлтийг 5 жилээр гарган мөрдөж байна. Тухайн байгууллагын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, үйлчилгээний хүрээ зэргийг харгалзан мэргэжилтний одоогийн хангалт ямар байгаад дүгнэлт хийж ойрын таван жилд ямар ямар мэргэжлийн зайлшгүй шаардлагатай ажлын байр бий болох хэрэгцээг тодорхойлон энэхүү хэрэгцээгээ үндэслэн хангалтын ажлыг зохион байгуулж байна. Эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, үйлдвэрлэл үйлчилгээний болон хууль хяналт, төрийн захиргааны байгууллагууд боловсон хүчний хэрэгцээний төлөвлөлтийнхээ дагуу шаардлагатай мэргэжилтнээ бэлтгэх, их дээд сургуулиудад оюутнуудыг гэрээгээр суралцуулах, Төрийн мэргэжсэн албан хаагчдыг Удирдлагын Академиар бэлтгэх, их дээд сургуулийг төрийн захиргааны удирдлага, менежер мэргэжлээр төгсөгчдөөр төрийн албыг бэхжүүлэн мэргэжсэн албан хаагчаар хангах арга хэмжээ авч ирлээ. Энэ онд төрийн албаны мэргэшлийн шалгалтыг гурван удаа зохион байгуулж явуулан багийн Засаг даргын нөөцөд бүртгэгдсэн 481 иргэнээс 97 нь Засаг даргад, 2 нь төрийн захиргааны албан тушаалд томилогдсон. Төрийн захиргааны албан тушаалын нөөцөд бүртгэгдсэн 161 иргэнээс 46 нь төрийн жинхэнэ албан тушаалд томилогдов.

### **Стратегийн зорилт 4. Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн болон цалин хөлс, хангамжийн тогтолцоог төгөлдөржүүлнэ.**

Төрийн албаны зөвлөлөөс боловсруулан гаргасан “Хүний нөөцийн мэдээллийн систем” программ хангамжаар боловсруулж буй мэдээллийг аймаг, сумын Засаг даргын Тамгын Газар, агентлаг, төсвийн байгууллагууд байгууллагынхаа хүний нөөцийн төлөвлөлт хийхэд ашиглаж байна.

Энэхүү мэдээлэл нь тухайн байгууллагын болон аймгийн хэмжээнд салбарын мэргэжлийн боловсон хүчний өнөөгийн хангамж, чадавхийг тодорхой хэмжээгээр харуулж байгаа учир аймгийн хэмжээнд бодлого боловсруулах чухал суурь үндэслэл болж байна.

Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан мэдээг харьяа агентлаг, сумдын Засаг даргын Тамгын Газар, төсвийн байгууллагуудаас гаргуулан авч программд шивж, аймгийн хэмжээгээр нэгтгэн товчоолж Төрийн албаны зөвлөлийн портал сайтад оруулав.

**Стратегийн зорилт 5. Төрийн албаны оновчтой хэмжээг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.**

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын Газар, хэлтэс, албад, Засаг даргын дэргэдэх агентлагуудын бүтэц, зохион байгуулалтыг Засгийн Газрын 2008 оны 67, 2009 оны 13 дугаар тогтоолын дагуу шинэчлэн зохион байгуулж ажиллуулахад Төрийн албаны салбар зөвлөлөөс судалгаа дүгнэлт гарган аймгийн Засаг даргад танилцуулан Засаг даргаас гаргах шийдвэрт тусгуулав. Сумын Засаг даргын Тамгын Газрын хуучин ажиллаж байсан орон тоо, албан тушаал /ажлын байр/-ын судалгаанд тулгуурлан нутаг дэвсгэр, хүн амын тоо, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүрээ, зайлшгүй шаардлагаар ажиллуулах ямар ажлын байрын хэрэгцээ байгаа зэргийг харгалзан сумдын Засаг даргын Тамгын Газарт ажиллах албан тушаалын жагсаалт гаргаж аймгийн Засаг даргаар зөвшөөрүүлэн чиглэл гаргуулав. Сумдын Засаг дарга түүний Тамгын Газраас гаргаж байгаа шийдвэрүүдийн эрх зүйн үндэслэл, иргэдэд үзүүлэх эрх зүйн сургалт, сурталчилгаа хангалтгүй байгаа учир энэ оноос сумдын Засаг даргын Тамгын Газарт нутгийн захиргаа, эрх зүйн асуудал хариуцсан ажилтан ажиллуулахаар шийдвэрлэж ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт боловсруулж хүргүүлсэн. Энэ дагуу сумдад эрх зүйч мэргэжлийн хүн ажиллуулахаар Төрийн албаны зөвлөлд сул орон тооны захиалга өгч нийтэд зарлуулан төрийн албаны мэргэшлийн шалгалтаар тухайн албан тушаалд томилогдох ажилтны нөөц бүрдүүлэн, нэр дэвшүүлж томилгоо хийлгүүлж байна.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**